

Шүүх шинжилгээний ерөнхий газрын
2025 оны 12 дугаар сарын 26 ны өдрийн
03/13322 тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ГАЗАР

2025 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах ажил, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үнэлгээг удирдлагаас өгсөн үүргийн дагуу Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Т.Буяндэлгэр, цагдаагийн хошууч Т.Нүрмаа, Эрдэм шинжилгээ, сургалт хөгжүүлэлтийн төвийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Э.Ижилцэцэг нар хяналт-шинжилгээ хийж, үнэллээ.

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд 4 арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгтээр харуулбал:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Заалтын тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					Дундаж хувь
			х/б	0-29	30-59	60-84	85-с дээш	
1	7.4.13. Хууль зүйн туслалцааны төв болон орон нутаг дахь улсын бүртгэлийн хэлтэс, шүүхийн шинжилгээний албаны ажиллах орчныг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	-	-	-	-	1	100
	7.4.21. Криминалистик, шүүх эмнэлэг болон тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулна.	1	-	-	-	-	1	98.7
	7.4.22. Шинжилгээний лабораториудад шинжилгээ хийх шинэ арга, аргачлалыг нэвтрүүлж, ДНХ, хими, физик, биологийн лабораториудыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, метохондр, бактериологийн шинжилгээний лабораториудыг шинээр байгуулна.	1	-	-	-	-	1	100

7.4.23. ДНХ-ийн нэгдсэн сан бий болгож, эрэн сурвалжлах болон нууц далд аргаар үйлдсэн, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэхэд ашиглана.	1	-	-	-	-	1	100
Нийт	4	-	-	-	-	4	99.7

(Биелэлтийг хавсралтаас үзнэ үү)

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-нд “Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлж ажилласан 4 арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаагүй байна.

7.4.21 дэх арга хэмжээний шүүх эмнэлгийн шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд хүрээнд “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22” хэрэгжүүлж байна.

Тус төсөл нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.6. “Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шинэ төрлийн шинжилгээний чанар, үр дүнг олон улсын жишигт хүргэж, шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.” гэсэн зорилтын хүрээнд “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22” төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг 2025 онд 30 хувьтай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, мөн төсөл хэрэгжих хугацаа сунгасан тул 2025 оны биелэлтийг гүйцэтгэлд тулгуурлан 92 хувиар үнэллээ.

ДҮГНЭЛТ

Шүүх шинжилгээний ерөнхий газар нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд 4 арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцын үнэлгээ 99.7 хувь буюу үр дүнтэй гэж үнэллээ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ 52 ДУГААР ТОГТООЛООР БАТАЛСАН “АЛСЫН ХАРАА-2050”
 МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ
 ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД ХАМААРАХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ
 (2025 оны жилийн эцсийн байдлаар)

2020 оноос хойш өссөн дүнгээр

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар
				Он	Түвшин		
	Бодлогын баримт бичгийн зорилго 1. Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.						
1	Зорилт 7.4. Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.						
1.1.	7.4.13.Хууль зүйн тусалцааны төв болон орон нутаг дахь улсын бүртгэлийн хэлтэс, шүүхийн шинжилгээний албаны ажиллах орчныг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Улс, орон нутгийн төсөв	Чанар	2021-2030	-	Шүүх шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадамж дээшилсэн байна.	Дорнод аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв 690,0 сая төгрөг , Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв 590,0 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс 2,489.2 сая төгрөгийн стандартын шаардлагад нийцсэн лабораторийн зориулалттай барилгыг бариулж үйл ажиллагаа явуулж байна. Мөн Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолоор Архангай, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн байрыг балансаас балансад шилжүүлэн авсан. Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2024 оны А/192 дугаар захирамжаар Өгөөмөр (1-р) багт 4104063532 нэгж талбарын дугаартай 3.0 га газрыг тус байгууллагад шинжлэх ухааны сорилт, туршилтын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэснээр алба хаагчдад практик дадлагыг зохион байгуулах боломж бүрдсэн. Байгууллагын үйл ажиллагаанд олон улсын “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015” стандартыг 2024 онд амжилттай нэвтрүүлж, БНСУ-ын “Баталгаажуулалтын

<p>байгууллага G-segf"-ыг Монгол Улсад албан ёсоор төлөөлж буй "Монсерфт" ХХК-аас 3 жилийн хугацаатай "Гэрчилгээ" олгосон бөгөөд 2025 онд "Магадлах-I" аудитад хамрагдаж, гэрчилгээг хадгалуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>АНУ-ын "Collaborative Testing Services"-ийн сорилтод 2023-2025 онуудад ДНХ, Хими, Митохондрин ДНХ, Цахим технологийн шинжилгээний лаборатори, шинжээчид, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгын Засгийн газрын Төв лабораторийн "Ханз бичигт хийх шинжилгээ"-ний олон улсын сорилтод Бичиг баримтын шинжилгээний лаборатори, шинжээчид тус тус оролцож, шинжилгээний үр дүнгээ олон улсаар баталгаажуулсан.</p> <p>Мөн "ISO/IEC 27001:2022 Мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, нууцлалын хамгаалалт. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Шаардлага" стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр 2025 онд "Төслийн баг" байгуулж, зөвлөх үйлчилгээний байгууллагыг сонгон шалгаруулж, стандартын 4, 5, 6, 7, 8 дугаар бүлгүүдэд хамаарах ажил, хавсралт 93 хяналтын матриц хийж, зөрүүний шинжилгээ, эрсдлийн үнэлгээ, мэдээллийн хөрөнгийн бүртгэл хийж, холбогдох 6 журмыг баталж, 17 удаагийн сургалт зохион байгуулан ажилласан байна.</p> <p>(Зарцуулсан төсөв:69.9 сая төгрөг).</p> <p>БНСУ-ын "КОЙКА" ОУ-ын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн "Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд ДНХ, Хими, Цахим технологи, Бичиг баримтын шинжилгээний лабораторид олон улсын стандартад нийцсэн, дэвшилтэд</p>					
---	--	--	--	--	--

технологи бүхий нийт 43 нэр төрлийн 80 гаруй тоног төхөөрөмж, 20 гаруй программ хангамж, 73 бусад хэрэгслийг хүлээн авч, 54 шинжээчийг холбогдох сургалтад хамруулж, шинэ төрлийн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлж, чадамжийг сайжруулсан.

Материаллаг баазыг бэхжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр: 2022 онд нийт 483.5 сая төгрөгийн зөөврийн дижитал рентген аппарат, физик, экологийн үзлэг шинжилгээ техник, тоног төхөөрөмжийг худалдан авахаас гадна “Киамоторс Монгол” ХХК-тай 708 сая төгрөгийн гэрээ байгуулан, экологийн үзлэг шинжилгээ болон цогцос тээвэрлэх тусгай зориулалтын 5 ширхэг автомашиныг худалдан авсан, **2023 онд** шүүх анагаах ухаан, инженер-техник, экологи, мөр судлал, биологи, автотехникийн шинжилгээний лабораторид нийт 412.1 сая төгрөгийн шинжилгээний тоног төхөөрөмж, багаж, хэрэгслээр хангаж, **2024 онд** ХЗДХСайдын 2024 оны хөрөнгө оруулалтын багцаас 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр 22 автомашинаар парк шинэчлэлт хийж, **2025 онд** ХЗДХСайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу урсгал зардлын санхүүжилтээр 691.6 сая төгрөгийн шинжилгээний багаж техник хэрэгслийг, 964.3 сая төгрөгийн магадлан итгэмжлүүлэхэд шаардлагатай шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийг, 3,300.8 сая төгрөгийн шинжилгээний эм урвалж бодис, эмнэлгийн хэрэгслийг, хөрөнгө оруулалтын зардлын санхүүжилтээр нийт 6 багц төндэрийн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулж, 2,895.8

1.2.	7.4.21. Криминалистик, шүүх эмнэлэг болон тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	Чанар	-		<p>сая төгрөгийн гэрээг байгуулан албаны хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг хүлээн авсан.</p> <p>Түүнчлэн Цахим технологийн шинжилгээний лабораторид 10 шинжилгээний программын лицензийн хугацааг сунгахад 238.7 сая төгрөг ("Форензик лаб Монголиа" ХХК), байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 249.4 сая төгрөг ("Инфосолюшн" ХХК) тус тус зарцуулсан байна (нийт 488.1 сая.төг).</p> <p>Бүсийн шүүх шинжилгээний төвүүдэд 2024 онд 17 нэр төрлийн тоног төхөөрөмжийг худалдан авч, материаллаг баазыг бэхжүүлсэн (Зарцуулсан төсөв:549.0 сая төгрөг).</p> <p>Галт зэвсгийн хонгио, хошууны автомат харьцуулалтын "Абис-Арсенал" нэгдсэн системийн салбар станцыг Дорнод, Ховд аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвд суурилуулан, тайлант хугацаанд хошуу 136, хонгио 188 авч санд баяжилт хийсэн.</p> <p>Тайлант хугацаанд давхардсан тоогоор орон нутгийн нийт 71 алба хаагчийг БНСУ, БНЭУ, ОХУ, Филиппин улсад зохион байгуулагдсан мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад, мөн орон нутгийн 2 алба хаагчийг АНУ, БНСУ-д зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хуралд оролцуулж, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулсан.</p>
						<p>Тус газрын цахим технологи, инженер-техник, автотехник, ДНХ, хими, физик, биологи, гарын мөр, мөр судлал, бичиг баримт, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээний зэрэг 12 шинжилгээний лаборатори нь ISO/IEC</p>

<p>технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулна.</p>		<p>17025:2017 (ISO/IEC 17025:2018) стандартын шаардлагыг хангасан тул Үндэсний Итгэмжлэлийн төвөөс 2025 онд "TL 217" дугаартай "Итгэмжлэлийн гэрчилгээ" олгосон.</p> <p>Үр дүн: Шүүх шинжилгээний тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, шинжилгээний үр дүн, шинжээчийн дүгнэлт "APAC" буюу Ази, Номхон далайн бүсийн байгууллагын 69 гишүүн орнууд болон "ILAC" олон улсын лабораторийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын 155 гишүүн оронд хүлээн зөвшөөрөгдөх болсон.</p> <p>Криминалистикийн шинжилгээний чиглэлээр: Олон улсын "ISO/IEC 17043" стандартаар итгэмжлэгдсэн БНСУ-ын "KOLAS" үр чадварын сорилтод 2023, 2024, 2025 онд 192 алба хаагч хамрагдаж, гэрчилгээ авснаар алба хаагчдын үр чадварыг олон улсад баталгаажуулсан.</p> <p>"Галт зэвсгийн хонгио хошууны нэгдсэн сан"-д 2024 онд тоног төхөөрөмж, программ хангамжийн шинэчлэлт хийж, 6 алба хаагчийг сургалтад хамруулсан. (Зарцуулсан төсөв: "Ньюкомпас" ХХК, 1,091.0 сая төгрөгийн төндэр).</p> <p>Мөн 2025 онд Гарын мөрийн адилтгалын "Адис-папирон" нэгдсэн сангийн системд шинэчлэлт хийж, 14 криминалистикийн шинжээчийг ОХУ-д практик сургалтад хамруулж, чадавхжуулсан.</p> <p>(Зарцуулсан төсөв: "Ньюкомпас" ХХК, 1,550.1 сая төгрөгийн төндэр)</p> <p>Үр дүн: Шинжилгээний нэгдсэн сангуудын хүчин чадал нэмэгдэж, мэдээллийг цахимаар бүртгэх, харьцуулан шинжлэх арга, аргачлал сайжирсан.</p>
---	--	--

Шүүх анагаах ухааны шинжилгээний чиглэлээр: Орчин үеийн стандартын шаардлага хангасан лаборатори бий болгож, иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай хүргэх, салах ёс гүйцэтгэх ажлыг хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор БНСУ-ын Эким банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)”-ийг эхлүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/15 дугаар тушаалаар “Төслийн удирдах хороо”-г, Сангийн сайдын 2025 оны 71 дүгээр тушаалаар “Төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг байгуулж, БНСУ-д 2024, 2025 онд 40 алба хаагчийг сургалтад хамруулж, мэргэшүүлээд байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/445 дугаар тушаалаар “Шүүх анагаах ухаан судлал” мэргэшлийн индекс авч, 2024 онд 10 резидент эмчид мэргэшлийн эрх олгоод байна.

ОХУ-д шүүх эмнэлэг, шүүх сэтгэцийн шинжилгээний чиглэлээр 2025 онд 6 алба хаагчийг сургаж, дадлагажуулсан.

Шүүх дүрс оношилгооны шинжилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан зөврийн дижитал рентген аппаратыг цогцос шинжилгээнд нэвтрүүлэх зорилгоор 2024 оны “24/2-010-161” дугаартай “Эрүүл мэндийн чиглэлээр рентген аппарат ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөл”-ийн гэрчилгээг авч, шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлсэн.

Байгалийн ухаан (Тусгай шинжилгээ)-ны чиглэлээр: “Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 2023 онд (Тусгай шинжилгээ) ДНХ, Химийн шинжилгээний лабораторид 39 нэр

						<p>терлийн 66 ширхэг тоног төхөөрөмж, 73 төрлийн бусад дагалдах хэрэгслийг суурилуулсан.</p> <p>Байгалийн ухааны шинжилгээний газрын 31 алба хаагчийг БНЭУ, БНСУ, АНУ, Япон, Филиппин, Тайланд, Швейцар, Вьетнам улсад зохион байгуулагдсан олон улсын хурал болон богино хугацааны сургалтад хамруулж, чадавхжуулсан.</p> <p>Үнэлгээ 98.7 хувь</p>
<p>1.3.</p>	<p>7.4.22. Шинжилгээний лабораториудад шинжилгээ хийх шинэ арга, аргачлалыг нэвтрүүлж, ДНХ, хими, физик, биологийн лабораториудыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, метохондр, бактериологийн шинжилгээний лабораториудыг шинээр байгуулна.</p>	<p>Улсын төсөв, гадаадын зээл тусламж</p>	<p>Чанар</p>	-		<p>ДНХ-ийн шинжилгээний лабораторид 5 төрлийн төхөөрөмж болон “аутосом, Y, X” хромосом, эзлэхүүн дахь ДНХ-ийн агууламж тогтоох шинжилгээний арга зүйг (нууцын зэрэгтэй) шинээр нэвтрүүлсэн бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар ДНХ-ийн эцэг тогтоох 665, ДНХ-ийн бусад 3259 шинжилгээ хийсэн.</p> <p>Монгол Улсын ҮАБЗ-ийн дэмжлэгтэйгээр Химийн шинжилгээний лабораторид 12 төрлийн техник, тоног төхөөрөмж, 10 төрлийн эмийн стандарт бодисыг хүлээн авснаар хуурамч эм, бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэгт шинжилгээ хийх боломж бүрдсэн. Мөн эмийн найрлагын бодисын тоон утгыг тодорхойлох зорилгоор “Thermo,S.G.50” багажийг худалдан авч лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинээр 4 аргачлалыг нэвтрүүлсэн.</p> <p>Үр дүн: Эмийн химийн нийт 139 нэр төрлийн 1546 ширхэг объектод 37 шинжилгээг, хүнсний нэмэлт, биологийн идэвхит бүтээгдэхүүний 834 объектод 10 шинжилгээг Олон улсын фармакопейн аргачлалын дагуу хийж, дүгнэлт гарган ажилласан бөгөөд Монгол улсын Эмийн бүртгэл мэдээллийн цахим системийн “Бүртгэлтэй эмийн жагсаалт”-д бүртгэгдээгүй 51 нэр төрөл, бүртгэлтэй 88 нэр</p>

						<p>төрлийн эмийн бүтээгдэхүүнийг илрүүлж ажилласан.</p> <p>Биологийн шинжилгээний лабораторийг Үндэсний ур чадварын сорилтын хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан “Иммуногематологийн шинжилгээний үндэсний чанарын гадаад үнэлгээ”-нд цусны бүлэг тодорхойлох шинжилгээний чиглэлээр амжилттай хамруулсан.</p> <p>Физикийн шинжилгээний лабораторийн алба хаагчдыг “Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ”-аас зохион байгуулсан “СGL РТ02 Хүдэр-2024” ур чадварын сорилтын 13-р тойрогт Физикийн шинжилгээний лаборатори тус тус амжилттай хамрагдсан.</p> <p>ХЗДХСайдын 2023 оны А/234 дүгээр тушаалаар Шүүх анагаах ухааны шинжилгээний хэлтэст “Бактериологийн шинжилгээний лаборатори”-ийг шинээр байгуулж, мөн сайдын 2025 оны А/09 дүгээр тушаалаар лабораторийн нэршлийг олон улсын нэр томьёонд нийцүүлэн “Шүүх микробиологийн шинжилгээний лаборатори” болгон өөрчилсөн бөгөөд ГХУСА33-ийн санхүүжилтээр (120.0 сая.төг) 6 төрлийн багаж, хэрэгслийг шийдвэрлүүлж, бэлгийн замаар дамжих 17 төрлийн халдварт өвчнийг тогтоох нөхцөл бүрдэж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 3904 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.</p> <p>Митохондрийн ДНХ-ийн шинжилгээний арга зүйг 2023-2024 онд боловсруулж, шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулснаар 2024 онд анх удаа 2 хүний дээжийг 1 эмэгтэй удмын хүмүүс болохыг тогтоосон. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/09 дүгээр</p>
--	--	--	--	--	--	---

<p>тушаалаар “Митохондрийн ДНХ-ийн шинжилгээний лаборатори”-ийг шинээр байгуулж, шинжилгээний арга, аргачлал бүхий 2 стандарт ажлын зааврыг шинээр баталсан.</p> <p>Үр дүн: 2025 оны жилийн эцсийн байдлаар 218 объектод, 17 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан бөгөөд хэргийн газраас хураан авсан махны дээжид митохондрийн “Cytb гений L14816, H15173, L14724”, “COI” генийн дараалал тогтоох шинжилгээг хийж, Олон Улсын генбанканд (NCBI) хайлт хийхэд Улаан номд орсон нэн ховор амьтан болох “Хандгай (Alces alces)”, Хулан адуу (Equus hemionus), Хүрэн баавгай (Ursus arctos) болохыг, мөн улсын хилээр авч гарах гэж байсан үл мэдэгдэх соёоны дээжүүдэд митохондрийн “Cytb”, “COI” генийн дараалал тогтоох шинжилгээ хийж, “Гэрийн тэмээ” (Camelus bactrianus) болохыг нотолж ажиллалаа.</p> <p>Мөн АНУ-ын Ойн албаны төслийн хүрээнд 2025 оны 11-р сард “Society for Wildlife Forensic Science” байгууллагын “Зэрлэг амьтан, ургамлын шүүх шинжилгээний стандарт ба удирдамж (SWFS)”-ийн дагуу митохондрийн ДНХ-ийн шинжилгээний лаборатори үнэлгээнд амжилттай хамрагдсан.</p> <p>Үр нөлөө: Монгол Улсын Шүүх шинжилгээний практикт анх удаа хийгдсэн шинжилгээ бөгөөд цаашид нэн ховор амьтан агнасан, тэдгээрийн эд эрхтнийг худалдаалсан, хил давуулсан зэрэг гэмт хэрэгт бүх төрлийн амьтны цус, эд, эрхтний хэсгээс митохондрийн генийн түвшинд тухайн амьтны төрөл зүйлийг тогтоож, дүгнэлт гаргах бүрэн чадамжтай болсон.</p> <p>Холбоос линк: https://nfa.gov.mn/site/single/425</p>					
--	--	--	--	--	--

						<p>Үнэлгээ 100 хувь.</p>
<p>1.4.</p>	<p>7.4.23. ДНХ-ийн нэгдсэн сан бий болгож, эрэн сурвалжлах болон нууц далд аргаар үйлдсэн, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэхэд ашиглана.</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Чанар</p>	<p>-</p>		<p>ДНХ-ийн генетик мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд 2024 онд худалдан авах сонгох шалгаруулалтын “УТ2401201099” дугаартай тендер зарлан, “ЮУКОМ ГРУПП” ХХК-тай генетик мэдээллийн сангийн программ хангамж нийлүүлэх гэрээг байгуулсан. (Зарцуулсан төсөв: 796.0 сая төгрөг)</p> <p>Нэгдсэн сан бүрдүүлэх, систем хөгжүүлэлт хийх зорилгоор Бүгд Найрамдах Турк Улсын “Vegisis” компанийн “Clims” системийг суурилуулж, алба хаагч нарыг дадлаажуулах сургалтад хамруулсан бөгөөд тус санг 2025 оноос бүрэн ашиглалтад оруулсан.</p> <p>Тайлант хугацаанд нэгдсэн санд 65521 биологийн дээжийн ДНХ-ийн мэдээллийг оруулж, баяжилт хийсэн.</p> <p>“КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 2023 онд ДНХ-ийн шинжилгээний лабораторид 26 төрлийн 66 ширхэг тоног төхөөрөмж, 34 төрлийн урвалж бодис, 12 төрлийн туслах хэрэглэгдэхүүнийг суурилуулж, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн бөгөөд үүний үр дүнд санд бүртгэгдсэн ясанд ДНХ-ийн шинжилгээ хийж, эзэнгүй 2 хэргийн хохирогчийг нотлон тогтоосон байна.</p> <p>Мөн АНУ-ын “Collaborative Testing Services (CTS)”-ийн сорилтод ДНХ-ийн шинжилгээний лаборатори 2, Митохондрийн ДНХ-ийн шинжилгээний лаборатори 1 удаа оролцож, хариуг баталгаажуулснаар дээрх лабораториудын шинжилгээний үр дүн олон улсад хүлээн зөвшөөрөгдөх боллоо.</p>

						<p>Байгалийн ухааны шинжилгээний газарт 2025 онд "80" градусын гүн хөлдөөгчийн төмөр тавиурыг суурилуулж, ахуйн хөлдөөгчид 2008 оноос хойш хадгалагдаж байсан цэвэршүүлсэн геномын ДНХ-ийн дээжийг ялган, шилжүүлж ажилласан. Ингэснээр ДНХ-ийн дээжийг удаан хугацаанд чанартай хадгалах нөхцөлийг бүрдүүлээд байна.</p> <p>ДНХ-ийн шинжилгээний урвалж бодис худалдан авах гэрээг "Сетунари" ХХК-тай 951.4 сая төгрөг, шинжилгээний туслах хэрэгсэл худалдан авах гэрээг "Занааспекс" ХХК-тай 224.3 сая төгрөгөөр тус тус байгуулж, сар бүрийн захиалгаар урвалж бодисыг хүлээн авч, ашиглан, шинжилгээг тасралтгүй, хэвийн явуулж байна.</p> <p>ДНХ-ийн шинжилгээний лабораториос 2023-2025 онуудад 7 алба хаагчийг БНСУ, БНСУ, АНУ, Япон, Филлипин улсад зохион байгуулагдсан олон улсын хурал болон богино хугацааны сургалтад хамруулж, дадлагажуулаад байна.</p> <p>Үнэлгээ 100 хувь.</p>
--	--	--	--	--	--	--

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР